



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

___ оны __ сарын __ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт,
чөлөөлөлт эдлүүлэх журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.15 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2009 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 523 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

3. Батлагдсан журмыг цахим татварын системд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Татвар төлөгчтэй харилцах газар /Д.Цогзолмаа/, Мэдээллийн технологи, статистикийн төв /Х.Батбаяр/-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД
ДЭД ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫГ АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ, АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ ЭДЛҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан чөлөөлөлт, 23 дугаар зүйлд заасан хөнгөлөлт эдлүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, 21.4-т заасан хувиар албан татвар төлж байгаа хувь хүнд энэ журмын дагуу чөлөөлөлт үзүүлж, хөнгөлөлт эдлүүлэхгүй.

1.3.Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлэхдээ Татварын ерөнхий хуулийн 15 дугаар зүйлд заасан хугацааг баримтална.

1.4.Татварын хөнгөлөлт эдлэх орлогын эх үүсвэр нь албан татвар ногдуулсан орлого байна.

1.5.Татвар төлөгч нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой нотлох баримтыг цаасаар эсхүл цахимаар ирүүлж болно. Цаасан хэлбэрээр ирүүлэхдээ шуудангаар илгээж болох бөгөөд энэ тохиолдолд холбогдох баримтыг нотариатаар гэрчлүүлсэн байна.

Хоёр.Албан татвараас орлого чөлөөлөх

2.1.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан орлогыг албан татвараас чөлөөлөхдөө албан татвар ногдох нийт орлогоос хасаж тооцно.

2.2.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан орлого олгож байгаа этгээд нь холбогдох хуульд нийцүүлэн тухайн орлогыг албан татвараас чөлөөлнө.

2.3.Суутган төлөгч нь хууль тогтоомжид тусгайлан заагаагүй “Хөдөлмөрийн дотоод журам” зэрэг зөвхөн тухайн байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжийг албан татвараас чөлөөлөхгүй.

2.4.Шүүхийн шийдвэрээр олгохоор тогтоогдсон цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдох бөгөөд албан татвараас чөлөөлөгдөх орлогод хамаарахгүй.

2.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоосон бичиг баримтыг үндэслэн хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлнө.

2.6.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4-т заасан малчин өрх, мал бүхий этгээдийн зөвхөн малын тоо толгойд ногдох орлогыг албан татвараас чөлөөлөх бөгөөд мал болон малын мах, сүү, арьс, шир, ноос, ноолуур, бусад түүхий эд, бүтээгдэхүүний борлуулалтын орлого чөлөөлөлтөд хамаарахгүй.

2.7.Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан гэр бүлийн гишүүд хоорондоо газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээгээ үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлогыг албан татвараас чөлөөлөхдөө бүртгэх эрх бүхий байгууллагын лавлагааг үндэслэнэ.

Гурав.Албан татварын хөнгөлөлт эдлүүлэх

3.1.Албан татвар төлөгч Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг эхэлж эдэлнэ.

3.2.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3-т заасны дагуу мөн хуулийн 23.1-т зааснаас бусад хөнгөлөлтийг төлсөн татварын хэмжээнд багтаан өөрөө сонгож эдэлнэ.

3.3.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.9-д зааснаас бусад албан татварын хөнгөлөлтийг 28 дугаар зүйлд заасны дагуу буцаан олгоно.

3.4.Албан татвар төлөгч гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 23.4, 23.5, 23.6, 23.10-т заасан хөнгөлөлтийг эдлүүлэхгүй.

3.5.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.14-т заасны дагуу албан татварын хөнгөлөлтийг хуульд заасан эцсийн хугацаанд тайлагнаж төлсөн албан татварын дүнгээс хэтрүүлэн эдлүүлэхгүй.

3.6.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.4, 28.1.5-д заасны дагуу албан татварын хөнгөлөлтийг хэсэгчлэн эдлэхгүй бөгөөд мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т зааснаас бусад хөнгөлөлтийг дараагийн татварын жилд шилжүүлэн эдлүүлэхгүй.

3.7.Энэ журмын 3.3-т заасны дагуу албан татварын хөнгөлөлтийг буцаан олгохдоо “Илүү төлсөн албан татварыг буцаан олгох, хяналт тавих, нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулах журам”-ыг баримтална.

3.8.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасан хөнгөлөлт нь үр тариа, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, түүний үр, суулгац, тэжээлийн ургамал, модны суулгацыг импортоор оруулсан буюу худалдан авч дамжуулан борлуулсан хувь хүнд хамаарахгүй.

3.9.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-д заасан хөнгөлөлтийг жилд нэг удаа эдэлнэ.

3.10.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 23.4-т заасан албан татварын хөнгөлөлтийг эдлүүлэхдээ дараах бичиг баримтыг үндэслэнэ:

3.10.1.төрийн мэдээлэл, солилцооны системээс гаргасан лавлагаа

3.10.2.татвар төлөгчийн бүрдүүлсэн дараах бичиг баримт:

3.10.2.1.орон сууцны захиалгын, эсхүл худалдах, худалдан авах гэрээ, хуулбарын хамт;

3.10.2.2.орон сууц худалдан авсан, банк, санхүүгийн байгууллагатай байгуулсан гэрээ, төлбөрийн баримт;

3.10.2.3.шинээр баригдсан орон сууц худалдан авсан тохиолдолд борлуулагч талаас олгосон Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий цахим төлбөрийн баримт /цаашид “и-баримт” гэх/;

3.10.2.4.хувьдаа орон сууц барьсан бол материал худалдан авсан төлбөрийн баримт, эсхүл хөрөнгийн үнэлгээний эрх бүхий байгууллагын үнэлгээний тайлан;

3.10.2.5.үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогын албан татвар төлсөн баримт;

3.10.2.6.орон сууц худалдан авах болон хувьдаа орон сууцны барилга барихад зарцуулсан орлого нь албан татвар ногдсон орлого болохыг нотолсон баримт.

3.11.Татвар төлөгч нь энэ журмын 3.10.1, 3.10.2-т заасан лавлагаа, бичиг баримтыг шуудангаар илгээж болох бөгөөд төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний лавлагаанаас бусад бичиг баримтыг нотариатаар гэрчлүүлсэн байна;

3.12.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т заасны дагуу 6 сая хүртэлх төгрөгийн хөнгөлөлтийг эдлүүлэх бөгөөд энэ нь 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш орон сууц худалдан авсан буюу барьсан татвар төлөгчид хамаарна.

3.13.Хөнгөлөлт эдлэх хувь хүн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т заасан өөрийн албан татвар ногдсон орлого гэдгийг нотлох үүрэг хүлээх бөгөөд нотолж чадаагүй тохиолдолд уг орлогод албан татварыг ногдуулж төлүүлсний дараа хөнгөлөлтийг эдлүүлнэ.

3.14.Хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т заасан “анх удаа орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авсан” гэдэгт 2020 оноос хойш хувьдаа орон сууцны барилга барьсан буюу худалдан авсан, 2006 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталсан хуулиар энэ төрлийн чөлөөлөлт эдэлж буцаан олголт авч байгаагүй татвар төлөгчийг хамааруулан ойлгож хэрэгжүүлнэ;

3.15.Хувьдаа орон сууцны барилга барьсан буюу худалдан авсан, 2006 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталсан хуулиар татварын чөлөөлөлтөө бүрэн эдэлж дуусаагүй татвар төлөгч 2020 онд үргэлжлүүлэн эдлэх бөгөөд татвар ногдох орлогоос хасаж чөлөөлөх орлогын нийт дүн 30 хүртэлх сая төгрөг байна.

3.16.Амьдран суух зориулалтаар барьсан буюу худалдан авсан орон сууцыг хамтран эзэмшигчээр 2 ба түүнээс дээш хувь хүн бүртгэгдсэн тохиолдолд тухайн орон сууцанд ногдох хөнгөлөлтийг зөвхөн нэг татвар төлөгчид эдлүүлнэ.

3.17.Хуульд заасны дагуу хөнгөлөлт эдэлж буй орон сууц эзэмших эрхийг худалдан борлуулах буюу бусад замаар бусдад шилжүүлсэн бол тухайн татварын жилд уг эрх шилжүүлсэн өдөр хүртэлх хугацааны хөнгөлөлтийг хувь тэнцүүлэн эдэлж дуусгана.

3.18.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.6-д заасан хөнгөлөлтийг дараах шаардлага, нотлох баримтыг үндэслэн эдлүүлнэ:

3.18.1.асран хамгаалагчаар тогтоогдсон гэдгийг Гэр бүлийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1-д зааснаар ойлгоно;

3.18.2.“тухайн татварын жилд төлсөн” гэдгийг Татварын ерөнхий хуулийн 6.1.28-д заасан хугацааг хамааруулах;

3.18.3.хуульд заасан анхны бакалаврын болон дипломын мэргэжил эзэмшигч гэдэгт бакалавр, дипломын мэргэжил эзэмших их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын сургуульд өмнө нь суралцаж мэргэжил эзэмшээгүй анхлан суралцагчийг хамааруулна. Дахин мэргэжил эзэмших, мэргэшүүлэх сургалт, магистр, докторын сургалтад суралцаж буй хувь хүний сургалтын төлбөр энэ хөнгөлөлтөд хамаарахгүй;

3.18.4.гадаад улсад хэлний бэлтгэлд сурч байгаа тохиолдолд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.6-д заасан сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамаарахгүй;

3.18.5.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.6-д заасан албан татварын хөнгөлөлтийг эдлүүлэхдээ дараах бичиг баримтыг үндэслэнэ:

3.18.5.1.төрийн мэдээлэл солилцооны системээс гаргасан лавлагаа;

3.18.5.2.татвар төлөгчийн бүрдүүлсэн дараах баримтууд;

3.18.5.3.сургалтын төлбөр төлсөн төлбөрийн баримт;

3.18.5.4.сургалтын төлбөр төлсөн төлбөрийн и-баримт;

3.18.5.5.гадаад сургалтын төлбөр төлсөн баримтыг баталгаат орчуулгаар орчуулж нотариатаар гэрчлүүлсэн байна. Сургалтын төлбөрт гадаад улсад амьдрах байр, хоолны мөнгийг хамааруулахгүй;

3.18.5.6.зээл олгосон банк, санхүүгийн байгууллагатай байгуулсан гэрээ, төлбөрийн баримтын хамт;

3.18.5.7.энэ журмын 3.18.3-т заасан анхлан суралцагчийг нотлох баримт.

3.19.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7-д заасны дагуу Засгийн газрын тогтоолоор батлагдсан тоног төхөөрөмжид хамаарах татвар төлөгчийн ирүүлсэн төлбөрийн баримт, төлбөрийн и-баримт, импортоор оруулсан бол гаалийн мэдүүлэг, гаалийн байгууллагад төлсөн албан татвар, хураамжийн баримт, техник, тоног төхөөрөмжийн гэрчилгээ зэрэг нотлох баримт, шаардлагыг үндэслэн хөнгөлөлтийг эдлүүлнэ.

3.20.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т зааснаар “...түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг” сэргээн засварлахад зориулж өгсөн хандивтай тэнцэх хэмжээний орлогод ногдох татварыг хөнгөлнө.

3.21.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10-т заасан хөнгөлөлтийг дараах шалгуурыг хангасан албан татвар төлөгчийн тайлант хугацаанд төлж, тайлагнасан татварын дүнгээр холбогдох нотлох баримтыг үндэслэн эдлүүлнэ:

3.21.1.Монгол Улсын иргэн байх;

3.21.2.хөнгөлөлт эдлэх орлого нь хуулийн 6.3.2-т заасан үйл ажиллагааны орлого байх;

3.21.3.“Улаанбаатар хотоос 500 км, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, сум” гэдгийг зам тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон улсын болон орон нутгийн чанартай авто замуудын эхлэл, төгсгөлийн цэгийн тодорхойлолтыг үндэслэх;

3.21.4.“алслагдсан аймаг, суманд оршин суудаг” гэдэг тухайн орон нутагт байнга амьдран суудаг болох нь эрх бүхий байгууллагын тодорхойлолтоор батлагдсан;

3.21.5.“тухайн орон нутагт бүртгэлтэй” гэдэгт тухайн орон нутагт оршин суух албан ёсны хаягаа иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгүүлсэн, уг бүртгэлтэй хаягт тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг.

Дөрөв.Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг тайлагнах, холбогдох баримт бүрдүүлэх

4.1.Хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх албан татвар төлөгч нь татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан “Татварын тайлан үйлдэх, тушаах, хүлээн авах, боловсруулах, тайланд залруулга хийх журам”-ын дагуу батлагдсан Хувь хүний орлогын албан татварын тайлан, хавсралт мэдээг нотлох баримтын хамт харьяалах татварын албанд ирүүлж татварын хөнгөлөлт эдэлнэ.

4.2.Суутгагч нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1-д заасан орлогыг албан татвар төлөгчид олгосон бол албан татвараас чөлөөлж, батлагдсан маягт, зааврын дагуу бусдад олгосон татвар суутгаагүй орлогыг тайлагнана.

4.3.Суутгагч нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан хөнгөлөлтийг эдлүүлэхдээ албан татвар төлөгчид олгосон татвар ногдуулах орлого, хөнгөлөгдөх татварын хэмжээг хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасны дагуу улирал бүр өссөн дүнгээр тооцож, зөрүүг залруулж тайлагнана.

4.4.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д заасны дагуу суутгагч нь мөн хуулийн 23.1-д заасан татвар ногдуулах орлого болон хөнгөлөлтийг 12 сард тэнцүү хувааж, тухайн ажилласан сард ногдох хөнгөлөлтийг эдлүүлнэ.

4.5.Хувь хүний хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5-д заасны дагуу албан татвар төлөгч нь хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан

татвар ногдуулах орлого, хөнгөлөлтийн жилийн эцсийн тооцоог хийж, тайланг тушааж болно.

4.6.Харьяалах татварын алба нь татвар төлөгчийн тайлан болон хөнгөлөлт, чөлөөлөлтийн нотлох баримтыг хүлээн авч хянан, цахим татварын системд оруулж цахим архив үүсгэнэ.

4.7.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан “Татварын тайлан үйлдэх, тушаах, хүлээн авах, боловсруулах, тайланд залруулга хийх журам”-ын дагуу тайлан ирүүлээгүй, буцаасан тайланг засварлаагүй, эсхүл хариу тайлбар ирүүлээгүй тохиолдолд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломжгүй.

4.8.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хүлээн авсан татварын тайланд үндэслэн Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх татвар төлөгчийн жагсаалтыг тухайн татварын албаны даргын тушаалаар баталгаажуулж, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4.2-т заасан хугацаанд багтаан буцаан олгох албан татварын хэмжээг хянан тодорхойлж, харьяалах төрийн сангийн нэгжид хүргүүлнэ.